

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2026 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/12.

Арвайхээр сум


Эрүүл мэнд, эм хангамжийн байгууллагын тусгай
зөвшөөрөл сунгах, шинээр олгох, нэмэлт
өөрчлөлт оруулах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, 19.3, 19.14, 19.15, 19.18, дэх заалт, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн 14, 15, Эрүүл мэндийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 10-ний өдрийн “Тушаал хүчингүй болгох тухай” А/40 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэнд, эм хангамжийн байгууллагад тусгай зөвшөөрөл олгох комиссын 2025 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн шийдвэрийг үндэслэн тусгай зөвшөөрлийг сунгах нэр бүхий 2 аж ахуйн нэгж, байгууллагын нэрийг нэгдүгээр, тусгай зөвшөөрөл олгож буй нэр бүхий 3 аж ахуйн нэгж, байгууллагын нэрийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл сунгасан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ үнэлгээ мэдээллийн хэлтсийн дарга (Я.Жаргалд)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Н.ОЮУНТУЯА

Эрүүл мэндийн газрын даргын
2026 оны 05 дугаар сарын 01-ны
өдрийн 4/2 дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт



ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ НЭР БҮХИЙ АЖ АХУЙН НЭГЖ,
БАЙГУУЛЛАГЫН НЭРСИЙН ЖАГСААЛТ

№	Байгууллагын нэр, регистрийн дугаар, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар	Үйл ажиллагааны чиглэл	Байршил	Тусгай зөвшөөрөл сунгах хугацаа	Хүчинтэй байх огноо
1	"Ирмүгэн Бэки" ХХК "Игүүшин фарм" эмийн сан РД-6964176 9011846672 ЭСХ-13/23/06	Нийтийн үйлчилгээтэй эмийн сан	Арвайхээр сум	5 жил	2031.05.26- ний өдрийг хүртэл
2	"Цалгин задгайт" ХХК "Цалгин задгайт" эмийн сан РД-3571831 1011121502 ЭСХ/13/23/04	Нийтийн үйлчилгээтэй эмийн сан	Баян-Өндөр сум	5 жил	2031.04.27- ний өдрийг хүртэл

---oOo---

Эрүүл мэндийн газрын даргын
2026 оны 05 дугаар сарын 01-ны
өдрийн 4/02 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт



ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР ОЛГОХ НЭР БҮХИЙ АЖ АХУЙН НЭГЖ,
БАЙГУУЛЛАГЫН НЭРСИЙН ЖАГСААЛТ

№	Байгууллагын нэр, регистрийн дугаар,	Үйл ажиллагааны чиглэл	Байршил	Шинээр олгосон огноо	Хүчинтэй байх хугацаа	Хүчинтэй байх огноо
1	"Оточ махагала" ХХК "Махагала" уламжлалтийн эмнэлэг 1011122172 РД-3589102	Уламжлалт эмнэлгийн оношилгоо, эмчилгээ, өдрийн эмчилгээ	Арвайхээр сум 5-р баг	2026.05.01	3 жил	2029.05.01 -ний өдрийг хүртэл
2	"Баян Бундаг" эмийн сан 1011122110 РД-3587835	Нийтийн үйлчилгээний эмийн сан	Арвайхээр сум 13-р баг	2026.05.01	3 жил	2029.05.01 -ний өдрийг хүртэл
3	ЗӨСТ-ийн "Ахуйн хортон шавьж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэлт " 1069001103 РД-9045996	"Ахуйн хортон шавьж, мэрэгч устгах, халдваргүйж- үүлэлт"-ийн үйлчилгээ	Арвайхээр сум 13-р баг	2026.05.01	3 жил	2029.05.01 -ний өдрийг хүртэл

---oOo---